



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 689
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Н.Ганзоригийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021396

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Ганзориг Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Ганзоригийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Н.Ганзоригт

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ ИРГЭН НАЯНТАЙН ГАНЗОРИГИЙН 2024 ОНЫ
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Хуванцар савны хэрэглээг багасгах ухуулга сурталчилгаа хийж, бараа зардаг дэлгүүрүүдэд зэвэрдэггүй хөнгөн цагаан сав гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй сав, уут худалдаалуулах бодлого баримтална.
- 1.2 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгт хамрагдалтыг өсгөж тогтмолжуулах бодлого баримтална.
- 1.3 Хүүхэд бие бялдар зөв дадал эзэмшиүүлэх зорилгоор стандартын тогтоолын талбайг сургуулийн орчимд байгуулах бодлого баримтална.
- 1.4 Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтийг нэмэгдүүлж, үний хөөрөгдлийг хязгаарлах бодлого баримтална.
- 1.5 Эмийн чанар, үнэ аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг цахимаар хянах боломжийг нэмэгдүүлж health.gov.mn цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хоёр. Боловсрол

- 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд сурах орчин бүрдүүлэх бодлого баримтална.
- 2.2 Ерөнхий боловсролын агуулга арга зүйд монголын түүх, хэл соёл, үндэсний уламжлал, нутгийн зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл сурахын ач тусыг тусган, хүүхдийг хөгжүүлэх амьдралын зөв дадал сургах бодлого баримтална.
- 2.3 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн сурагч нэг бүрийг боловсролд тэгш хамруулах бодлого баримтална.
- 2.4 Дотуур байрны гал тогоог стандарт болгох бодлого баримтална.

Гурав. Аялал жуулчлал

- 3.1 Хануй, цагаан голын рашааны хүрмэнд оруулсан нойлын үйл ажиллагааг гэрээ байгуулан иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хариуцуулан өгөх бодлого баримтална.
- 3.2 Хануй, цагаан голын рашаан, Шарга нуурт морь, сарлаг унуулах үйлчилгээг бий болгох бодлого баримтална.
- 3.3 Нүүдлийн аж ахуй өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, малчин өрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "малчин айлын гэр түрээс" бий болгох бодлого баримтална.
- 3.4 Орон нутгийн онцлогийг шингээсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж аялагч, жуулчдад худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална.
- 3.5 Малын гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан Баян-Агт сумын нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, байнгын болон түр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд тогтмол худалдаалах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална.

Дөрөв. МАА, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

- 4.1 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.

- 4.2 Баг бүрт өвс тэжээлийн нөөц бий болгох бодлого баримтална.
- 4.3 Малын тоо толгойн албан татвараар хийгдэж байгаа ажлуудыг иргэдэд сурталчилна таниулж, тэдний бодит саналд тулгуурласан ажил үйлчилгээг төлөвлөх бодлого баримтална.
- 4.4 Тахиа, зөгийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж өргөжүүлэх бодлого баримтална.

-оОо-

